



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/98

Цагаан-Уул сум

**Баяр наадам зохион байгуулах салбар
комисс томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Ардын хувьсгалын 103 жил, сум байгуулагдсны 93 жилийн ойн баяр, Цагаан-Уул хайрханы овоо тахилга наадмыг сумын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх баяр наадмыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, Цагаан-Уул хайрханы овоо тахилга наадмын хандив цуглуулах ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Баяр наадмын бэлтгэл ажлын төлөвлөгөөг комисс тус бүрээр гаргаж батлуулан ажиллахыг зохион байгуулах комиссын дарга нарт үүрэг болгосугай.
3. Үндэсний их баяр наадам, Цагаан-Уул хайрханы овоо тахилга наадмыг ардын өв уламжлалаа хадгалж, сахилга бат, нийгмийн дэг журмыг сахин, ёслол хүндэтгэлийн өндөр хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэхийг нийт наадамчин олонд уриалсугай.
4. Баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд орон нутгийн хөгжлийн сангаас 5.000.000 төгрөг гарган зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр), Санхүүгийн албаны дарга (Ш.Эрдэнэцэцэг) нарт зөвшөөрсүгэй.
5. Энэхүү Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-д даалгасугай.

ДАРГА

С.ТОНЧИГНЯМ



/Zahiramj 2024/